

## ХЯТАДЫН ШИНЭЧЛЭЛИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

*Н.Ариунгуа\**

Оросын Алс Дорнодын Институтын Зүүн Азийн иргэншлийн харьцуулсан судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан түүхийн ухааны доктор А.Виноградов “Хятадын шинэчлэлийг судлах арга зүйн асуудалд” хэмээх сонирхолтой өгүүлэл нийтлүүлжээ. (Проблемы Дальнего Востока 2006 №2 с.115-128) Энэхүү өгүүлэлд зохиогч Хятадын хөгжлийн үйл явц, мөн чанар нь Европынхоос зарчмын ялгаатай бөгөөд тэрхүү өвөрмөц шинж чанар нь түүхийн хөгжлийн үе шатыг дамжсаар Хятадын өнөөгийн хөгжил шинэчлэлийн өвөрмөц дүр төрх шинж чанарыг бүрэлдэн бий болгосон талаар маш дэлгэрэнгүй өгүүлжээ.

Зохиогч хоёр иргэншлийн хөгжлийг /Европ, Хятад/ “Нийгэм-байгалийн түүхийн концепци” /социо-естественная концепция истории/ хэмээх онолын хүрээнд авч үзээд нийгмийн хөгжлийн зүй тогтол нь хүрээлэн буй байгаль, цаг агаарын онцлогоос хамаардаг бөгөөд чухамхүү энэхүү хүчин зүйл нь аливаа нийгмийн онцлогийг тайлбарлах гол түлхүүр хэмээн үзжээ.

Европын ихэнх бүсэд цаг агаар, байгалийн нөхцөл байдал нь хүний нийгэм хийгээд хүрээлэн буй орчны хооронд антогонизм үүсгэж улмаар хүн байгалийн хоорондын харилцааг зохицуулагч нь хөдөлмөрийн багаж зэвсэг болж байжээ. Улмаар эрт дээр үеэс Европын иргэншил нь дэвшилтэт хөдөлмөрийн багаж, техникийн тусламжтайгаар зөвхөн үнэт зүйлсээ уламжлан авах замаар хуучин нийгмээ халж шинэ нийгмийг цогцлоон байгуулсаар иржээ. Хүн болон байгалийн хоорондох харилцаа нь нийгмийн харилцаанд тусгалаа олж, улмаар зөрчил антогонизм Европын иргэншлийн дотоод шинж чанар нь болсон ажээ. Энэхүү байдал нь мөн Европын философийн хөгжилд нөлөөлсөн бөгөөд хэдий эртний философ-чид хүмүүний аж байдалд зөрчил /Гераклит/, harmony /зохицолдлого/ гэсэн ойлголт /Пифагор/ аль аль нь байсан боловч цаашид Европын хөгжлийн түүхэнд зохицолдлого гэсэн ойлголт бараг үгүй болж, арга зүйн гол үндэс нь Гегелийн диалектикийн эсрэг тэсрэгийн зөрчлийн 3 хууль болсон байна. /118/

Нийгмийн амьдралын өөрчлөлт нь чухамдаа нэг нь нөгөөгөө үгүйсгэдгээс улбаатай гэсэн ойлголт нь “нийгэм-эдийн засгийн формаци” /хэвшлийн онол/ хэмээх онолыг бий болгож тэр нь марксизмд нэлээд системчлэгдэн өнөөг хүртэл Европын түүхийг судлах үндсүүдийн нэг болсон ажээ. /119/

\* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Нийгэм эдийн засгийн формаци буюу нийгмийн байгууламжийн хэлбэрүүдийн гол шинж нь анги болон өмчийн харилцааны ялгааг багтаадаг бөгөөд чухамхүү тэдгээр нь Европын түүхийн хөгжлийг тасралтгүй үйл явцаар дүрсэлдэг. Нэг формаци нөгөөгөөр солигдох нь системтай үйл явц учир хувьсгалт өөрчлөлтийг шаарддаг байна. Иймээс хувьсгалыг барууны философич, нийгэм судлаачид түүхийн хөгжлийн үндсэн хэлбэр гэж үзсээр иржээ. Чингэхдээ хувьсгалыг өдөөгч гол шалтгаан нь хөдөлмөрийн дэвшилтэт багаж зэвсэг, техник болдог байна.

Дорно зүгийн иргэншлийн хувьд гэвэл, тэдгээрийн хөгжил нь гол төлөв байгалийн тааламжтай нөхцөлд явагдаж байсан учир хүн ам нь ургамал ан амьтны адил байгальдаа дасан зохицож ирсэн бөгөөд энэ нь ялангуяа Хятадын түүхэнд маш тод илэрлээ олжээ. Байгаль орчныг амьдралын гол тэтгэгч, харин хүний үйл ажиллагаа нь түүнд учруулах аюул занал гэж үзэж байв. Энэхүү байгальтайгаа зохицолдлох үзэл нь нийгмийн амьдралд шууд тусгалаа олж Хятадад /эхэн үедээ/ анги болон засаглалын тухай үзэл баримтлал бүрэлдэн бий болоход саад болжээ. Түүхийн хэд хэдэн үеийн туршид үйлдвэрлэх хүчний гол хүчин зүйл болох газар хүн хоёрын хоорондын тааламжтай харьцаа нь хувийн өмч ноёрхоход саад болов. Нийгмийн аливаа нэгжид зайлшгүй гардаг хувийн санаачилга нь нийгмийг тодорхойлох тогтвортой үзүүлэлт болж чадаагүйгээс улбаалан нийгмийн онцгой бүлэглэл бүрэлдэн бий болоогүй байна. Гэр бүл, ахмаддаа захирагдах иерархи /шатлан захирах ёс/ шинж чанар бүхий харилцаа нь нийгмийн харилцааг бүхэлд нь зохицуулж байсан байна. Өөрөөр хэлбэл анги, хувийн өмч бус харин гэр бүл нийгмийн гол институт болж байв. Төрийн зохион байгуулалт нь гэр бүлийн харилцааны хэв маяг, шинж чанарыг өвлөн авчээ. Овгийн байгууламж нь энэхүү нөхцөлд анги бүрэлдэн бий болоход саада болж байв. Кунзын сургаалын ёс суртахууны хэв хэмжээ нь нийгмийн харилцааг зохицуулж байсан бөгөөд энэхүү харилцаа нь тэмцлийг бус харин нь зэрэгцэн орших нөхцлийг бий болгож байв.

Дотоод зөрчлийн нуугдмал байдлаас хамааран Хятадын түүхийн хөгжлийн шинж чанар үгүйсгэл, зөрчлөөр бус харин хуримтлал, залгамж чанараар тодорхойлогдох болжээ. Хятадын нийгмийн энэхүү тогтвортой байдал нь тухайн нийгмийг гэнэтийн өөрчлөлтийг даван туулах чадваргүй болгож, айвуу тайван амьдралд нийцүүлэн зохицуулав. Зарчмын өөрчлөлтөнд дасан зохицох механизм нийгэмд огт бүрдээгүйгээс болж урьдын нийгмийн тогтолцоо нь бага зэргээр засварлагдах төдийгөөр хязгаарлагдан солигдож байжээ. Нийгмийн хөгжил дэвшлийг хэмжих хэмжүүр нь гол төлөв ёс суртахууны хэв

хэмжээ байсан бөгөөд соёлын уламжлалын тасралтгүй шинж чанар нь өнгөрсөн үеэ дахин шүтэхэд хүргэжээ. /120/

Энэхүү бүрэлдэн бий болсон соёл иргэншил нь дотоод соёлын уламжлалаар хамгаалагдаж байсан учир түүнийг устгах бараг боломжгүй байв. Устгахад маш хүчтэй түрэмгий вирус шаардлагатай байсан бөгөөд Хятадын нийгмийн дотор ч, түүний орчин тойронд ч тийм хүч байсангүй. Хятад гүрэн нь өөрийг нь эзлэн түрэмгийлсэн ард түмнийг хүртэл уусган тэдэнд хөгжлийнхөө хэв маягийг тулган хүлээлгэж чадаж байв. Түрэмгийлэлд өртөх гадаад нөхцөл байгаагүй, эцгийн ёсны өнгө аястай оюун санааны нэгдмэл шинж чанар хийгээд хүн амын тогтвортой өсөлт нь нийгмийн харьцааны хөгжлийг удаашруулж байжээ. Энэ бүгд нь Хятадад нийгэм- улс төрийн чанартай үндсэн өөрчлөлт /Европын ойлголтоор/ явагдахад саад болж байв.

Хятадын соёл иргэншил нь залгамж чанар, зохицолдлого, хамтын үзлээр тодорхойлогдож Хятадын философи нь ч, зөрчил тэмцлээр дүүрэн аж амьдралаас үүссэн Европын философитой харьцуулах юм бол байгаль нийгмийн хоорондын зохицолдлогын үзлээр нэвт шингээстэй нигүүлсэнгүй, хүлээцтэй шинж чанартай байжээ. Үүнийг Хятадын уламжлалт шашин хийгээд Күнзын сургаалиас харж болох билээ. Гэвч Хятадын нийгэмд зөрчил огт байгаагүй гэсэн үг биш бөгөөд зөвхөн зөрчил, зохилдлого, нийгмийн хөгжлийн тасралтгүй болон тасрамтгай шинж, ангийн сонирхол, гэр бүлийн харьцаа зэргийн хоорондын харьцаа нь Европынхоос зарчмын хувьд өөр байсан гэсэн үг юм. Мэдээж, ийм төрлийн нийгмийг удирдахад өвөрмөц удирдлагын арга барил шаардлагатай байжээ. /121/

Ийнхүү А.Виноградов эрт дунд зууны Хятадын нийгмийн хөгжлийн онцлогийг тоймлон өгүүлснийхээ дараа эртний уламжлалт энэхүү соёл иргэншил нь глобалчлалын эрин үед хэрхэн шинэчлэгдэж байгаа талаар өгүүлсэн байна.

Барууны орнуудын техникийн давамгай байдал нь ХҮИИ-ХИХ зуунд нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг бий болгосон нь автономитоор /бие даан/ оршиж байсан соёлын органик элементуудыг өөрчлөх, устгах үйл явц явагдаж барууны соёлоос зээлдэн дууриах хандлага хүчтэй өрнөж эхэлсэн байна. “Өрнөчлөгдөх “үйл явц нь өрнөдийн орнуудын гадаад улс төрийн бодлогод нийцэж байсан хийгээд зорилго нь хөгжилтэй орнуудын тэргүүлэх давамгай байр суурийг бэхжүүлж бусад ард түмнүүдийн өвөрмөц соёлыг устгахад оршиж байжээ. /121/

Гэвч зохиогчийн үзэж байгаагаар өрнөчлөгдөх энэхүү үйл явц, зөвхөн хандлага байсан бөгөөд заавал дагаж мөрдөх шаардлагатай зүйл биш байжээ. ХХ зуунд барууны маягийн институт нь дорно зүгийн

орнуудад алинд нь ч тэр чигээрээ хуулбарлагдаагүй, хэдий нийгэм-эдийн засгийн амьдралд гарсан барууны нөлөө багагүй байсан боловч дорно зүгийн орнуудын уламжлалт соёл нь өөрийгөө хамгаалах тэмцлийн явцад дахин үржин хөгжих дотоод нөөц бололцоогоо дайчлан зэрэгцэн оршин тогтнож чадсан байна. Чингэхдээ эдгээр орнууд нь барууны орнуудын хөгжлийн замыг сохроор хуулбарлаагүй ч гэсэн өөрийн түүхийн хөгжлийн ердийн хэв маягаа алдахад хүрсэн. Хөгжилтэй орнуудын хөгжлийн загвар нь нийт хүн төрлөхтний нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь болсон байна.

60-аад оны эхэнд бий болсон шинэчлэлийн онолын гол агуулга нь тэргүүний техник, технологи дэлгэрч, эдийн засаг либералчлагдаж, аж үйлдвэржсэн нийгмийн бүтцийн нөхөн үржилт, үндэсний элитийн нийгэм улс төрийн чиглэл хандлага нь барууны хөгжлийн замд өөрийн эрхгүй яваандаа хүргэнэ гэсэнд оршиж байв. Гэвч шинэчлэлийг зөвхөн хөрөнгөтний нийгмийн индустриал соёлтой ижилсүүлж болохгүй гэсэн шүүмжлэл колонийн систем нуран унаснаар өрнөж эхэлжээ. Зүүн Европ дахь социалист систем нуран унаж Азид 90-ээд орнуудад эдийн засгийн хямрал үүссэнээр барууны хөгжлийн онол дахин сэргэж ирсэн байна. Глобалчлалын онол нь модернизацийн онолын үндсэн санааг өвлөн авсан боловч энэхүү онолын гол санаа нь уламжлал шинэчлэлийн хоорондын зөрчил биш, харин глобал хөгжил ба үндэсний өвөрмөц хэв маяг хоорондын харьцаанд оршиж байгаа гэжээ. Өөрөөр хэлбэл глобалчлал нь онолын хувьд дэлхийн хөгжлийн нэгдмэл шинж чанарыг бус харин орон тус бүрийн өвөрмөц шинжийг тодотгоход оршиж байгаа гэжээ. Зохиогч мөн барууны хэв маягаар глобалчлалын үйл явцыг хөгжүүлэхийг сонирхож буй хүмүүс, объектив үйл явцыг өөрийн хувийн эрх ашиг сонирхолд нийцүүлэхийг зорьж байгаа талаар өгүүлсэн байна. Нөгөө талаас зохиогч модернизацийн үзэл санаа онолын хувьд зөвхөн газар нутгийн хүрээнд бус нийгэм-түүхийн орон зайд ч мөн тусгалаа олох ёстой. Глобалчлал нь хөгжлийн шинэ хэв маягийн хувьд одоогоор зөвхөн дэлхийн тодорхой бүс нутагт илэрлээ олж байгаа бөгөөд энэ нь формацийн онолд ч, иргэншлийн онолд ч боловсрогдоогүй гэжээ. /122/ Энэхүү глобалчлал нь үндэсний уламжлал, барууны универсализмын хоорондын синтез мэтээр дүрслэгдэж байгаа бөгөөд тухайн улс орны нийгэм соёлын уламжлалт хөгжлийн зүй тогтолыг харгалзахаас гадна, мөн улс гүрнүүдийн улс төрийн удирдлагын хүчин чармайлтыг ихээр шаардах ажээ.

**Социалист модернизаци.** Хувьсгал бол түүхийн өөрчлөлтийн зүй ёсны хэлбэр мөн хэмээх үзэл баримтлал нь өрнөдийн бус орнуудын түүхийн хөгжлийн хэв маягийг өөрчлөх маш тохиромжтой арга зам байсан байна. Марксизм нь нийгмийн хөгжлийн онолын хувьд өөртөө

үнэт зүйлийг мөн агуулж байсан бөгөөд түүний гол үзэл болох хамтын зарчим /коллективиз/ нь дорно зүгийн орнуудын нийгмийн хэв маягт яв цав нийцэж байв. Цаашдаа ч уламжлалт соёл нь марксизм-социализмын тусламжтайгаар өөрийн өвөрмөц хэв маягийг хадгалж чадсан. Хувьсгалт өөрчлөлт, янз бүрийн туршилт, завхрал, алдаа онооны үр дүнд уламжлалт нийгмийн байгуулалтын үндэс суурийг сэргээн босгож чадсан байна. Энэхүү байгуулалтын гол шинж нь нийгмийн гэсэн ойлголтыг улсын гэсэн ойлголттой адилтгах, нийгмийн эрх ашгийг хувь хүнийхээс дээр тавих, нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдрал дахь төрийн үүргийг баталгаажуулах, улс төрийн удирдлагын нарийн эрэмбэ дарааллыг чанд сахих зэрэг байв. Энэхүү систем нь хэдий барууны орнуудын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хөгжлийн түвшинд хүрэх зорилтыг биелүүлж чадаж байсан боловч төрийн удирдлагын залгамж шинж чанарыг бүрдүүлэх механизм байхгүй байсан нь түүний дутагдал байв.

XX зууны 80-90 онуудад БНХАУ нь засаглалыг шилжүүлэх механизмыг бүрдүүлж чадсан бөгөөд энэ нь төр засгийн бүтэц, улс төрийн соёлын нөхөн үржих системийн гол зангилаа нь болсон байна. Хятадын “хоёр дахь үеийн” коммунистуудын удирдагч “шинэчлэлийн эцэг” Дэн Сяопинаас “гурав дахь үеийн” коммунистуудын удирдагч Зян Земинд, Зян Земинаас Ху Зинтаод засаг шилжүүлэх аажуу, шат дараалсан, маш нарийн зохион байгуулалттай үйл явцаас харахад Хятад улс төрийн удирдлагын тогтвортой хэлбэрийг олсон гэж хэлж болно. Ийнхүү Хятад улс, уламжлалын нөөц, орчин үеийн хөгжлийн шаардлагыг хослуулсан хөгжлийн хэв маягийг бүрдүүлжээ. /125/

50-иад онд дэлхийн коммунист хөдөлгөөнд социализмын үндэсний өвөрмөц загвар бий болсон нь социализм нь Европын универсализмаас салсныг гэрчилж байв.

Өнөөгийн Хятадын нийгмийн зохион байгуулалтын зарчим, өмчийн харилцаа, нийгмийн харилцаа, улс төрийн систем зэргийг авч үзэх юм бол Хятадын шинэчлэлийн концепцийг марксизмын онолын үнэт зүйлтэй адилтгахад бэрхшээлтэй буюу огт бололцоогүйг харуулж байна. /126/ Хятад улс социалист модернизацийн замыг сонгохдоо өөрийн уламжлалт соёлоо огоороогүйг нийгэм, улс төр-эдийн засгийн хөгжлийн загвар нь нотолж байна.

Ер нь Зүүн Азийн модернизаци нь эдийн засгийн хөгжлийн асуудлыг амжилттай шийдвэрлэж буй хамгийн тод жишээ юм. Эдгээр орнууд нь баруунаас юу хийхийг олж мэдэнгүүтээ яаж хийхийг өөрсдөө шийдвэрлэсэн юм. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаан, технологийг Күнзын иргэншлийн уламжлалт давуу талтай хослуулж чадсан юм. “Социалист” Хятадаас авахуулаад “капиталист” Япон хүртэлх эдгээр орнуудын

эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралд ижил төстэй зүйлүүд байх бөгөөд тэдгээр нь: төр нь нийгмийн бүхий л салбарт шийдвэрлэх үүрэг рольтой, эдийн засгийн салбарт улсын сектор давамгайлдаг, улс төрийн системд нэг нам болон нэг тэргүүлэгч давамгайлж байдаг бөгөөд нэр хүнд нь тэдгээрийн ёс зүйгээс шууд хамаардаг. /126/

XX зуунд Оросын болон Хятадын коммунист намууд марксизмын тусламжтайгаар ялалт байгуулсан боловч өөрийн үндэсний уламжлалт соёлын шахалт, дарамтын нөлөөн дор марксизмын гол гол заалтуудаас татгалзахад хүрсэн. Нийгэм-улс төрийн практикт тэд марксизмаас зөвхөн түүхийн өөрчлөлтийн талаархи арга зүйг ашигласан болно. /126/ Ийнхүү индустриал иргэншлийн вирусээр халдварласан уламжлалт соёл иргэншил нь ямартай ч өөрийн нөхөн үржих чадвараа сэргээж чадсан юм. Чингэхдээ энэхүү уламжлалт соёл нь өөрчлөлтийг, тэгэх тусмаа гадны нөлөөн доорхи шинэчлэлийг огт үгүйсгэхгүй байгаа боловч энэхүү өөрчлөлт нь барууны ойлголтын дагуу үйлдвэрлэлийн аргачлал нь нийгмийн амьдралын бүхий л салбарт нөлөөлж шууд тов тодорхой үр дүнг авчрах бус харин нарийн төвөгтэй үйл явцыг араасаа дагуулдаг. Модернизаци нь, түүн дотроо “социалист модернизаци” нь бусдын соёлд уусан алга болох бус харин өөрийн үнэт өвөрмөц зүйлээ хадгалах замаар орчин үетэйгээ интеграцичлагдаж байгаагийн тод жишээ юм /126/ гэжээ.

Ийнхүү А.Виноградов өөрийн бичсэн энэхүү сонирхолтой өгүүлэлдээ улс орон өөр өөрийн хөгжлийн зүй тогтолтой бөгөөд тухайн зүй тогтолын дагуу уламжлал, соёлын дүр төрх, хөгжлийн хэв маяг бүрэлдэн бий болдог. Барууны соёлын нөлөөн дор барууны хөгжлийн замыг шууд хуулбарлавал уламжлалт соёлын шахалт, дарамтын дор өөрийн хөгжлийн өвөрмөц хэв маягийг хүссэн хүсээгүй хүлээн авахад хүрдэг гэсэн санааг агуулжээ.

Хятад Орос орнууд нь XIX зууны 2-р хагасаас барууны нөлөөнд автан ирсэн боловч байнга өөрийн гэсэн хөгжлийн замыг эрэлхийлэн хайсаар иржээ. Тухайлбал Хятад улс шинэчлэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ өөрийн замнасан хөгжлийн замыг үгүйсгэн шууд барууны маягаар улс төрийн шинэчлэл хийлгүй харин уламжлал, хуримтлуулсан туршлаган дээр үндэслэн хөгжлийн хэв маягаа сонгон авсан нь глобалчлалын эринд өвөрмөц үндэсний дүр төрхөө хадгалах бололцоог бүрдүүлсэн ба улс орон бүр өөрийн хөгжлийн зүй тогтолыг танин мэдэж хөгжлийнхөө дүр төрх, замаа сонгох нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлсэн байна. Энэ нь глобалчлалын эрин үед өөрийн хөгжлийн замыг сонгох гэж бүдэрч яваа манай улсын хувьд бодуштай чухал санаа юм.